

ЗҮҮН ХОЙТ АЗИЙН ИНТЕГРАЦИД СУДАЛГААНЫ СҮЛЖЭЭНИЙ ҮҮРЭГ РОЛЬ

*Ц.Баатар**

Эдийн засгийн глобалчлал улс үндэстнүүдийн эдийн засгийг бараа бүтээгдэхүүн, хөрөнгө капитал, мэдээлэл, технологи, ажиллах хүчний гэсэн нэгэн зах зээлд нэгтгэн интеграцчилах үйл явц урьд өмнө байгаагүй хурдтай өрнөн хөгжиж буйгаар илэрч байна гэж үзэж болох юм. Юу боловч дэлхий ертөнц маань улам бүр глобалчлагдахын хирээр хүмүүс, корпорациудын үйл ажиллагааны хамрах хүрээ нь улс үндэстний хил хязгаар, хөрш зэргэлдээ бүс нутгаас даван тэлж дэлхийн хэмжээнд яригдах боллоо. Түүнчлэн мэдээлэл холбооны технологийн салбарт хийсэн шинэчлэлүүд нь холбооны хүчин чадал хурд, чанар, хэмжээ далайцыг дэлхий нийтийн хэмжээнд үлэмж өргөжүүлж үйлчилгээний үнэ тариф нь жил ирэх бүр үнэмшмээргүй хурдан хямдрах болов. Энэ хирээр глобалчлалын үйл явц улам бүр хурдсах чиг хандлагатай болж байна.

Ингэснээр эдийн засгийн үйл ажиллагаанууд илүү хурдан, үр өгөөжтэй болж оюунжсан үйлдвэрлэлийн орчин, үйлчилгээний багтаамж тэлэн өргөжиж, дэлхийн эдийн засгийн өсөлт хөгжлийн хүчирхэг хурдасгуурын нэгэн чухал хүчин зүйл нь мэдээллийн технологи болж байна.

Бизнесийн ертөнцийн хувьд түргэн борлогдох бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний багтаамжтай зах зээл нэгэнт нээгдлээ. Ийм нөхцөлд аль ч орны ямар ч компани богино хугацааны дотор олон улсын хүчирхэг компани боллоо өсөн дэвжих боломж нээлттэй боллоо. Үүний зэрэгцээ хөл дээрээ зогссон компаниуд өнөөдөр нэгдэн нийлж үндэстэн дамнасан корпораци болж үйл ажиллагаагаа явуулах тохиромжтой байршлаа товлон тогтоодог нь өнөөгийн шатны нэгэн онцлог болов. Энэ нь хөрөнгө оруулалтын таатай боломжийг эрэлхийлсэн үлэмж хэмжээний хөрөнгийн урсгал глобал зах зээлд бий болгож байна.

Түүнчлэн глобалчлалтай нэгэн зэрэг технологийн болон тогтоосон хязгаарлалтуудаас хамаарч олон улсын өрсөлдөөнд хамрагдаж чаддаггүй байсан салбарт хүртэл өрсөлдөөн улам бүр эрчимтэй өрнөх боллоо. Жишээ нь: корпорациуд өөрсдийн бизнесийн үйл ажиллагаа явуулах тодорхой улс орныг сонгодог ч гэсэн бидний амьдран буй энэ цаг үед тэд глобал өрсөлдөөний нөлөөнөөс хамаарахгүй байх ямар ч боломжгүй юм.

*Ц.Баатар - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D), дэд профессор

Гэсэн хэдий ч, глобалчлалын бүхий л өгөөжийг улс орон бүртгш хүртээд байх боломж өнөө хэр бүрдээгүй л байна. Өнөөгийн практикаас үзэхэд том жижиг ямар ч улс орон аль болох глобалчлалын боломжийг ашиглах, түүнд дасан зохицох, уялдуулан зохицуулахад үйл ажиллагаагаа чиглүүлж байна. Глобалчлалыг үл хайхарсан улс орнуудын хувьд дараах шалтгааны улмаас эдийн засгийнх нь хөгжил зогсонги байх магадлал өндөр аж. Үүнд:

1. Олон улсын хэмжээнд өрсөлдөгч корпорациуд болон хүний нөөц нь бизнесийн илүү таатай боломж, орчныг эрэлхийлнэ.
2. Хөгжилд зайлшгүй шаардлагатай гадаадын сангууд болон шууд хөрөнгө оруулалт багасна.
3. Үр ашгаа хангалттай дээшлүүлж чадаагүй компаниуд тухайн зах зээлийг орхихоос өөр аргагүйд хүрнэ.

Нөгөө талаар глобалчлалын өнөөгийн эринд үлэмж хэмжээний хөрөнгө мөнгийг хоромхон хугацаанд дэлхийн аль ч өнцөг буланд хүргэх боломж олгосон мэдээлэл, холбооны технологийн хөгжил нь дэлхийн эдийн засгийг тогтворгүйжүүлэх гол хүчин зүйлийн нэг боллоо. Энэхүү гоц үзэгдэл нь Азийн валютын хямралын үед нотлогдсон бөгөөд шинэ тулгар зах зээлтэй орнуудын санхүүгийн хямралын үед давтагдсан билээ.

Өнөөдөр шинэ технологийг бүрэн дүүрэн ашиглах боломж олгохуйц мэргэжлийн шинэ орчин дэлхийд шаардлагатай болж байна. Дээр дурдсанчлан, газар зүйн хязгаарыг давж гарсан эдийн засаг нь харилцан хараат байх явдлыг гүнзгийрүүлж, улмаар санхүүгийн болон санхүүгийн бус арилжааны замаар дамжин глобал хэмжээнд өөр хоорондоо үлэмж хамааралтай байх болжээ. Иймд олон улсын санхүү эдийн засгийн системүүд түүний хуучирсан тоглоомын дүрэм журмын аль алийг нь глобалчлалын өнөөгийн эриний шинэ нөхцөлтэй уялдуулан шинэчлэх шаардлага ч гарч байна.

Үүний хамт улс хоорондын саад тотгоруудыг арилгаснаар глобалчлал нь олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих боллоо.

Эдийн засгийн глобалчлалыг залан чиглүүлэгч тэргүүлэгч хүч нь өдгөө Дэлхийн Худалдааны Байгууллага (ДХБ) болоод байна.

Энэхүү байгууллага нь олон улсын гэрээ хэлэлцээрийг сахиулах үүрэгтэйгээр 1995 онд байгуулагдан улмаар Тариф, Худалдааны Ерөнхий Хэлэлцээрийг (ТХЕХ) баталсан билээ. Энэ байгууллагын 143 гишүүд нь дэлхийн эдийн засгийн үйл ажиллагааны их нөөц болдог.

Өнөөгийн эдийн засгийн бараг бүхий л салбарт худалдаа, хөрөнгө оруулалтын “либеральчлал” чухлаар тавигдаж байна. Хувьчлалыг

гүнзгийрүүлж, эдийн засагт төрийн оролцоог багасгах, худалдаанд учруулдаг саад тотгорыг арилгах асуудал дэлхий нийтийн хандлага боллоо. Өнөөдөр байгалийн нөөц, ялангуяа дэлхийн ойн болон усны глобал хомсдолыг хамгаалах хандлага амьдрал дээр хүчтэй илэрч байна. Жишээ нь зөвхөн дотоодын хууль тогтоомжууд нь заримдаа глобал асуудлыг шийдвэрлэхэд гол саад тотгор болдог аж. Үндэсний болон олон улсын эдийн засгийн бодлогуудын түүхэн өөрчлөлтийн энэ цаг үед дэлхийн ой мод, усны глобал хомсдолыг хэрхэн шийдвэрлэх вэ гэдэг асуудал өнөөдөр глобалчлалын шийдвэрлэвэл зохих чухал асуудал болон байнга тавигдах боллоо.

Энэхүү хил хязгааргүй шинэ эдийн засагт орон нутгийн холбоод болон бүс нутгууд өөрсдийн ой, усны нөөцийг хэтрүүлэн хэрэглэж байгаа бол тэдэнд хэн хаанаас хяналт тавих вэ? Дэлхийн улаан номонд орсон амьтдыг хамгаалахад хор учруулах дан ганц төрийн зохицуулалтгүй глобал зах зээлд бүх үйлдвэрлэгчид нэгдэх явдлыг хэрхэн яаж хийх вэ? Жишээ нь Бразили улс мод бэлтгэх гадаадын аль болох олон компаниудыг Амазон руу оруулахыг зөвшөөрч хөрөнгө оруулалтын хуулиндаа хийсэн өөрчлөлт ямар үр дүнд хүрэх вэ? Индонези улс ой модны салбараа өргөжүүлж гадаадын зээлдүүлэгчдээс төлбөрийг Олон Улсын Валютын Сангаас тулгасан нөхцлөөр хийх болзол тавьбал юу тохиолдох вэ? Биологийн төрөл зүйлээрээ дэлхийд тавд ордог Мексикийн цаасны үйлдвэрлэлд худалдаа, хөрөнгө оруулалт илүү их орвол юу болох вэ? Усны нөөцийн хувьд ч мөн нэгэн адил. Монгол Улсын хувьд аваад үзэхэд өнөөдөр нүдээ аниад уулын олборлох үйлдвэрийг хөгжүүлэх нэрээр хаа сайгүй газар сэндийлж, байгаль экологийн тэнцвэр алдагдуулж, горхи булаг ширгэж, усны нөөц хомсдож цөлжих аюул нүүрлээд байгаа нь дан ганц Монголын асуудал биш болоод байна. Үүнийг глобал хүрээнд шийдвэрлэхгүйгээр дан ганц Монголын дотоодын хэрэг гэж үзэх боломжгүй. Монголын шороон шуурга яван явсаар АНУ, Канадын нутагт буудаг болохыг ярьсаар удаж байгаа. Тэд ч зүгээр хараад суухгүй л болов уу. Саяхнаас Мянганы замаас арай сонсголонтой мянганы ногоон хэрэм байгуулах тухай яриа өрнөлөө. Энэ төсөл дэлхийн олон нийтийн дэмжлэг тусалцаа авах магадлал өндөр, хэрэгжих боломжтой төсөл юм. Гагцхүү түүнд зориулсан хөрөнгийг буруу замаар зувчуулах нүх сүвийг сайн хааж, хяналтыг хүчтэй болгох тал дээр шинэ арга барилаар хандах аваас өнөөгийн өндөр технологийн эринд түүнийг ургуулж тордоход төдий л их бэрхшээл учрахгүй болов уу.

Дээр өгүүлсэн усны асуудлыг давтан үргэлжлүүлэхэд энэ чиглэлийн судалгаа, шинжилгээний дүнгээс үзэхэд өнөөдөр манай гаригийн усны нөөц бидний эрэлт хэрэгцээг хангаж чадахгүй нь нэгэнт тодорхой болжээ. Эдүгээ 30 гаруй улс усны гачаалд орж нэг тэрбум гаруй хүнд ундны цэвэр ус хүрэлцэхгүй байна гэсэн НҮБ-ын статистикийн тоо баримт бий. Үйл ажиллагааны хүрээ хязгаар, бохирдлоос болж дэлхийн ундны усны нөөц нь 30 хүрэхгүй жилийн хэрэглээг нэг дахин нэмэгдүүлсэн хэрэглээг л хангах боломжтойг шинжлэх ухаан тогтоожээ.

2025 он гэхэд дэлхийн хүн амын гуравны хоёр нь усны гачаалтай хүнд нөхцөлд амьдрах нь.¹

“ХХ зуунд газрын тос ямар их чухал хэрэгтэй байсны адил ХХI зуунд ус тэр хэмжээнд тавигдана” гэж Фортуна сэтгүүлд тэмдэглэжээ. Сүүлийн үед дэлхий нийт усыг цэнхэр алт хэмээн нэрийдэх болов.

Үнэндээ худалдаа, хөрөнгө оруулалтын хэлэлцээр оргил үедээ хүрэхээс илүү ус хүн төрөлхтний болоод гариг ертөнцийн эрх ашгийг хөндөх болов. Үүнтэй уялдуулан Глобалчлалын Олон Улсын Чуулга (GFI), Усны Глобалчлалын Төслийнхөн усны глобал нөхцлийн талаар дэлхийн хүн ардыг төлөөлсөн тунхаглалын төслийг усны гачаалд ороод буй Боливи Улсын Кочабамбагийн иргэдтэй хамтран 2000 оны 12 дугаар сард боловсруулжээ. Энэхүү тунхаглалын үзэл санаа бидний монголчуудад ч хамааралтай тул түүний гол санааг хөрвүүлэн та бүхний сонорт хүргэх нь зүйтэй гэж үзлээ. Гэхдээ энэ тунхаглалын талаар манай энэ чиглэлийн мэргэжлийн байгууллага илүү өргөн мэдээлэлтэй байгаа нь мэдээж. Миний хувьд зөвхөн өргөн олон нийт мэдэж байхад илүүдэхгүй гэсэн санааны үүднээс хандав.

Кочабамбагийн Тунхаглалд “Боливи, Канад, АНУ, Энэтхэг, Бразилийн иргэд, фермерүүд, ажилчид, нутгийн уугуул ард түмэн, оюутнууд, мэргэжилтнүүд, байгаль орчны ажилтнууд, багш сурган хүмүүжүүлэгчид, төрийн бус байгууллагууд, ахмадууд, бид бүхэн устай холбоотой амин чухал эрх ашгаа хамгаалахад хүчээ нэгтгэх, эв санааны нэгдлээ илэрхийлэхээр өнөөдөр энд цуглараад байна... Глобалчлалын талаарх санаачлагуудын туйлын зорилго нь иргэд өөрсдийн засгийн газраар дамжуулан хамтын үйл ажиллагаагаа зохицуулах боломжийг ашиглахад оршино. Үүний тул дэлхийн хүн ард бидэнтэй нэгдэхийг уриалж байна”² гэжээ.

Үүнтэй холбогдуулан дурдахад сүүлийн үед дэлхийн эдийн засгийн байгууллагууд, зарим нэг улс орны эрх баригчид олигархиудтайгаа

хамсан үндэснийхээ эдийн засагт хүндрэл дарамт учруулдаг явдалтай тухайн орны иргэд шийдвэртэй тэмцэл явуулахыг уриалсан байдаг. Тухайлбал, ДХБ-ын нэгэн ажилтны “Файнэншил Таймс”-т өгсөн ярилцлагад “ДХБ нь дотоодын эдийн засагтаа дарамт үзүүлдэг бүлэглэлүүдтэй хуйвалдсан засгийн газрын эсрэг зогсоно” гэж тэмдэглэжээ.³ Энэ мэт нэг орны хүрээнд бие даан шийдвэр гаргах асуудал хумигдсаар байна. Үүний жишээ болгож Монгол Улсыг аваад үзье. Буурай хөгжилтэй, хараат эдийн засагтай, хүнд сурталт авилгалын ардчилсан засаглалтай, зах зээлийн боловч халамжийн эдийн засгийн бодлого явуулдаг, ДНБ-ийхээ 45 гаруй хувийг улсын төсөвтөө зарцуулдаг дэлхийн бараг цорын ганц орон. ОУВС, ДБ, АХБ зэрэг олон улсын валют санхүүгийн байгууллагуудын оролцоогүйгээр улс орныхоо дотоодын тулгамдсан асуудлыг засгийн газар бие даан шийдвэрлэх ямар ч боломжгүй.

Сүүлийн үед худалдаа хөрөнгө оруулалтын асуудал хөгжиж байгаа орнуудын өсөлт хөгжлийн уг сурвалж болж тэр нь цаашлаад бүс нутгийн интеграцийг хөгжүүлэх нэгэн хүчин зүйл болох хандлагатай байна. Энэ чиглэлээр хийсэн судалгааны бүтээлүүдэд үүнийг цохон тэмдэглэх болов.

Худалдаа болон гадаадын шууд хөрөнгө оруулалт нь (ГШХО) бүсчлэлийг бэхжүүлэх нотолгоо болж, “бүс нутгийн буюу хэсэгчилсэн глобалчлал”-ыг бий болгож байна гэж зарим судлаачид үзэж байна.⁴

Энэ бүхнээс үзэхэд аль ч орны ард иргэд хүний өдөр тутмын амин хэрэгцээ болсон ус мэтийн глобал асуудалд онцгой анхаарал хандуулж түүнийг хамгаалахад бүх нийтийн хөдөлгөөн өрнүүлж, засгийн газартаа шахалт үзүүлж энэ чиглэлд нэгдсэн бодлого хэрэгжүүлж буй аж. Манайд ч гэсэн чандмань эрдэнэ болсон усны асуудалд онцгой анхаарал тавьж бодлого боловсруулах нь өнөөгийн тулгамдсан асуудлын нэг болоод байна. Түүнчлэн энэ асуудал зөвхөн тухайн улсын асуудал бус бүс нутгийн хэмжээний, цаашлаад дэлхий нийтийн глобал асуудал болох тул юуны өмнө бүс нутгийн хэмжээнд хамтран ажиллах нэгдсэн сүлжээ бий болгох асуудал өнөөдөр чухал ач холбогдолтой байж болох юм. Иймд энэ талаар зөвхөн нэг жишээ болгож судалгааны сүлжээ байгуулах боломжийн талаар нэлээд тодорхой авч үзье.

Эдийн засгийн бүсчлэл ба сүлжээ

“Глобалчлал”-ын нэг чухал үр дагавар нь глобал системийн хүрээнд улс орнуудын бүсийн холбоодыг байгуулж дэд бүс бүрэлдэх нөхцлийг бий болгодог жишээ олон байдаг. Тухайлбал Европын Холбоо

(ЕХ), Америкийн Чөлөөт Худалдааны Бүс (ФТАА), Хойт Америкийн Чөлөөт Худалдааны Хэлэлцээр (NAFTA), Зүүн Өмнөд Азийн Үндэстний Нийгэмлэг (АСЕАН) болон Ази, Номхон Далайн Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа (АПЭК), Зүүн Хойд Азийн гурван улс Солонгос, Хятад, Японы АСЕАН+3 г.м.

Өнөөдөр ийнхүү бүс хоорондын эдийн засгийн хамтын ажиллагааг хялбар дөхөм болгоход чиглэсэн үйл явц өргөжин тэлсээр байна. Эцсийн бүлэгт энэ бүхэн хамтран ажилладаг байгууллагуудын сүлжээг дамжин бүс нутгийн хамтын ажиллагаанд суурь нь болж өгөх юм.

Мэдээллийн шинэ технологи нь глобалчлалын эриний хөгжлийн чухал хүчин зүйл юм. Энэ нь дотоод зангилаануудыг холбосон сүлжээний дотоод зүй тогтол дээр үндэслэнэ. Эдгээр зангилаанууд нь өргөн хүрээтэй олон төрөл зүйл байж болно. Жишээ нь: глобал санхүүгийн урсгалын сүлжээн дэх хөрөнгийн зах зээл болон тэдгээрийн туслах үйлчилгээний төвүүд байж болох юм. Тухайлбал мод бэлтгэх, усны гачаал, орчины бохирдол зэрэг энгийн бөгөөд тулгамдсан асуудлуудыг судлах замаар хоорондоо холбогдсон их сургуулийн судалгааны төвүүд байх боломжтой.

Иймэрхүү судалгааны нэгдсэн сүлжээ нь Зүүн хойд Азийн эдийн засгийн бүсчлэлд чухал үүрэг гүйцэтгэх үндэслэл бий.

Бие даасан улсын суурь нь үндэсний үзэл байдгийн нэгэн адил ЗХА-ийн сүлжээ нь бүсийн бүлэглэлүүдийн ашиг сонирхолд нийцсэн тодорхой үзэл санааг бий болгох боломжийг бүрдүүлнэ.

Иймээс ЗХА-д эдийн засгийн бүс бүрдүүлэх амин чухал үйл явцыг хурдасгах хүчин зүйл нь судалгааны нэгдсэн сүлжээ байгуулах асуудал гэж үзнэ.

Сүлжээний хүрээнд хийх судалгаа

ЗХА-ийн бүсийн үзүүлэлтийн талаар өмнө өгүүлсэн тойм дээр үндэслэн судалгааны ажилд нэмэр болох зорилгоор судалгаа хийж эхлэх боломжтой хувилбаруудыг энд авч үзье.

1. ЗХА-д эдийн засаг, нийгэм, улс төрийн харилцан үйлчлэл хэдий чинээ гүнзгийрнэ тэр хэмжээгээр хамтын ажиллагаа үлэмж өсөн өргөжих болно. Энэхүү бүсийг байгуулснаар глобал аль ч түвшинд өрсөлдөөний давуу чанар нэмэгдэж дотоод үйл ажиллагааны элдэв зардал багасна.

2. Мэдээллийн хадгалалт, дамжуулалт, дүн шинжилгээнд технологийн шинэчлэл хийх, түүнчлэн холбоо, тээврийг сайжруулах замаар харилцан хамаарлыг улам бүр нэмэгдүүлнэ. Өөрөөр хэлбэл ийм бүсийн гол тодорхойлох шинж нь хүмүүс, бараа бүтээгдэхүүн,

мэдээлэл, технологийн хөдөлгөөний өсөлтөөр тодорхойлогдоно. Ийм хөдөлгөөн нь нэн тэргүүнд бүсийн гол зангилаа хотуудад бий болно.

Тэгэхлээр, иймэрхүү бүсүүд нь бүсийн архитектор, хүн ам зүй, эдийн засаг, нийгэм, улс төрийн хэсгүүдийг нэгтгэсэн “нэгдмэл орчин” болох “шинэ газар нутгийн сүлжээ”-гээр тодорхойлогдоно гэсэн үг.

3. Бүсийн интеграцчлалын үйл явц нь “глобал соёл” хэмээн тэмдэглэгддэг глобалчлалын шинэ хүчнүүд, юуны өмнө үндэсний нутаг дэвсгэр, түүхэн уламжлалаа хамгаалдаг бие даасан улсуудын хооронд зарим зөрөлдөөнийг бий болгож болзошгүй гэдгийг энэ чиглэлийн судлаачид болгоомжлуулж түүнээс зайлсхийх арга замыг тодорхойлохыг эрмэлздэг. Иймэрхүү зөрөлдөөн гарч болох газруудын жишээнд олон улсын нисэх буудлууд, худалдааны төвүүд, усан боомтын шинэчлэл, жуулчдын сэтгэлийг татах байгууламж барих гэх зэргийг судлаачид дурьдаад, тэр орчны байгуулалтад бие даасан улсын зүгээс санал зөрөлдөөн гарч ч болзошгүйг анхааруулсан байдаг.

Глобалчлалын үр нөлөөгөөр бий болох эдгээр шинэ хөгжлийн дийлэнх нь бүсийн гол гарцын зангилаан дээр төвлөрдөг учир дээрх хандлагуудыг цаашид хурцатгадаг. Иймээс бие даасан улс, глобалчлалын хүчнүүдийн хооронд гарсан санхүүгийн маргаан нь нийт бүс нутагт тэгш бүс байдлыг бий болгоход олонтаа нөлөөлдөг болохыг судлаачид тэмдэглэж байна.⁵

Дээрхи нөхцөл байдлыг харгалзан судалгааны үндсэн чиглэл дараах байдалтай байж болох юм.

Хамтын ажиллагааны өргөжилт, хөрөнгийн урсгал хөдөлгөөн, бие даасан улс, глобал хурцадмал байдал гэсэн бүсчлэлийн дөрвөн түлхүүр үзэл-дотоод зүй тогтол нь ЗХА-ийн бүс дэх судалгааны ажлын үндсэн элементүүдэд зайлшгүй орох болно.

Судалгааны эдгээр чиглэлийг хэрхэн зохион байгуулах болон судалгаа шинжилгээний хамтын ажиллагааг хэрхэн хялбар дөхөм болгох вэ? гэдэг нь дараагийн асуулт юм.

Өнөөг хүртэл ЗХА-ийн бүсийн орнууд өөр хоорондын харилцан хамаарлын хувьд нэлээд ажлыг уялдуулан зохицуулж хамтран ажиллаж ирлээ. ЗХА-ийн их сургуулиудын захирлууд тогтмол уулзаж байна. Мөн судалгааны хүрээлэн, төвийн захирлууд, судлаачид тогтмол уулзаж байна. Багш, оюутан солилцооны хоёр талын олон тооны хэлэлцээрийн дагуу бүсийн орнуудын оюутан солилцооны хөтөлбөр жил бүр байнга өсөн нэмэгдсээр байна. Бүс нутгийн орнууд улсын болон хувийн хэвшлийн

түвшинд судалгааны олон байгууллагууд үйл ажиллагаа хамтран явуулдаг, олон улсын чанартай хурал, семинар тогтмол явуулдаг боллоо.

Ийм Судалгааны сүлжээ байгуулж болох нэг жишээг би энд дурдахыг хүсч байна. Жишээ нь Оросын Владивосток, Сөүл, Хятадын Жилин муж, Пхеньян, Улаанбаатар дахь судалгааны хүрээлэнгүүд, их сургуулиудийг хамруулан Японы Нийгатагийн ЗХА-ийн Эдийн Засгийн Хүрээлэн гол зохицуулагч байхаар судалгааны нэгдсэн сүлжээ байгуулж болох юм. Энэ саналыг дэвшүүлж буй үндэслэл гэвэл 90-ээд оноос хойш бүс нутгийн орнуудын судлаачид бараг жил бүр тогтмол уулзаж санал бодлоо өргөн солилцож ирлээ.

Энэхүү бүсэд бий болох “судалгааны сүлжээ” нь миний бодлоор бол мэдээллийн энэ эриний хэрэгслүүд гэж нэрлэх зүйлсэд нэгэнт түшиглэсэн байх нь дамжиггүй. Өнөөгийн байдлаар бүс нутгийн орнуудын Зүүн хойт Ази Судлалын төвүүд бараа бүтээгдэхүүн, хүмүүсийн хөдөлгөөнд эрх зүйн орчин хэрхэн нөлөөлөх талаархи судалгааг явуулж байна. Цаашид сүлжээнд орсон хүрээлэн, төвүүдэд хандаж хүсэлт гаргасан захиалагчдад зориулсан хамтарсан судалгаа байж болох юм.

Түүнчлэн судалгааны сүлжээ нь ЗХА-ийн бүсийн интеграци, өөрчлөлт шинэчлэлтийн үйл явцад онцгой ач холбогдол өгч судлах шаардлагатай.

Дээр дурдсан зүйлүүдийг үндэслэн судалгааны дараахи долоон гол сэдвийг санал болгож болох юм. Үүнд:

- ЗХА-ийн бүсчлэлийн дотоод зүй тогтлын судалгаа;
- ЗХА-ийн бүсийн харилцан хамаарлын төлөв байдлын судалгаа;
- Тухайн бүсийн эдийн засаг, санхүүгийн бодлогын судалгаа;
- Хөрөнгө оруулалтын боломжийн талаархи судалгаа;
- ЗХА-ийн бүс дэх глобалчлалын шинэ хүчнүүд болон үндэстэн хоорондын хурцалмал байдлын талаархи судалгаа;
- Бүсийн гол “гарцын зангилаа”-нуудад илэрсэн шинэ газар нутгийн талаархи судалгаа;
- Бүс дэх хүнс-хүн ам- орчин-эрчим хүчний уялдаа холбооны талаархи судалгаа

Эдгээр сэдвийн судалгаанд нилээд нухацтай хандах нь зүйтэй тул дээрх судалгааны долоон чиглэлийн заримд нь би анхаарал хандуулья.

Зүүн Хойд Азийн интеграцид чиглэсэн судалгааны сүлжээ бий болгох нь

Ийм судалгааны гол цөм нь ЗХА-ийн бүсийн хөгжиж байгаа орнуудын /Монгол, Хойд Солонгос/ эдийн засгийн шилжилтийн талаар харьцуулсан менежментэд чиглэх ёстой болов уу. Ялангуяа Монголд менежмент туйлийн доод түвшинд байгааг хэлэх хэрэгтэй. Үр дүнтэй менежмент, удирдан зохицуулагдах үйл явцын ойлголт, менежерүүдэд тохирсон сургалт, мэдээлэл цуглуулах оновчтой систем болон эдгээр үйл явцын менежмент, ялангуяа соёлын хам сэдвээр судалгаа явуулж болох юм.

ЗХА-ийн бүсэд байгаа их сургуулиудын судалгааны төвүүд түүнчлэн хүрээлэнгүүд энэ сүлжээг хөгжүүлэх боломж бий. Энэ сүлжээнд их сургуулиуд, судалгааны төв, хүрээлэнгүүд, түүнчлэн хувийн хэвшил, засгийн газруудад байгаа судалгааны төвүүдийг ашиглаж болох юм. Эхний шатанд ЗХА-ийн бүлгийн их сургуулиуд, хүрээлэн, төвүүдээс эхэлж болох боловч ЗХА-ийн бүсийн бус орнуудын их сургуулиуд, судалгааны хүрээлэнгүүдийг ч татан оролцуулж болох юм. Тухайлбал, АНУ, Австрали, Тайван гэх мэт. Судалгааны төвүүдийн сүлжээний зорилт нь урьд өмнө шүүн хэлэлцсэн бүс нутгийн хүрээ дэх төслүүдийг тогтоож тодорхойлох зэрэгт чухал ач холбогдолтой байж болох юм. Үүнд:

1. ЗХА дахь эдийн засгийн бүс, дэд бүсийн байж болох хувилбар
2. ЗХА-ийн бүсийн харилцан үйлчлэлийн төлөв байдлын судалгаа
3. Бүс нутаг дахь эдийн засаг, санхүүгийн бодлогын судалгаа
4. Бүс нутаг дахь хөрөнгө оруулалтын боломжийн судалгаа
5. ЗХА-ийн бүс нутаг дахь глобалчлалын шинэ хүчнүүд ба үндэстэн-төр, засаглалын хоорондын судалгаа
6. ЗХА-ийн бүс нутагт “гарцын зангилаанууд”-ыг үүсгэсэн шинэ “газар нутгийн сүлжээ”-ний судалгаа
7. ЗХА-ийн бүс нутаг дахь хүн ам орчин-эрчим хүчний уялдааны судалгаа зэрэг болно.

Мөн санал болгож байгаа эдгээр судалгааны төслүүд нь судалгааны сүлжээний сонгосон загварыг л зөвхөн төлөөлж чадна гэдгийг хүлээн зөвшөөрвөл зохино. Цаашлаад соёлын судалгааны сүлжээг санаачлах боломж буй нь тодорхой. Жишээ нь глобалчлалын энэ шинэ эринд хувийн хэвшлийн болон төрийн салбарын менежментийн сургалтын асуудлуудыг судлах боломжууд маш их байгаа билээ. Судалгааны ийм төслүүдийг хурал, семинар болон харилцан хамаарал бүхий электрон сүлжээгээр нарийвчлан боловсруулж болно. Үүнийг

амжилттай хэрэгжүүлэхэд ЗХА-ийн эдийн засгийн бүсийн хөгжлийн өсөлтийн судалгаа чухал ач холбогдолтой гэдгийг засгийн газрууд, санхүүжүүлэгч агентлагууд болон хувийн хэвшлийнхэн ойлголцох ёстой. Сүлжээгээр дамжин бүлгийн хүчин чармайлтыг хялбарчилж чадах “протоколууд”-ын талаар бүсийн орон бүрийн их сургуулиудын судалгааны төвүүд, хүрээлэнгүүд тохиролцоонд хүрэх шаардлагатай. Ийм протоколд хөтөлбөр, төслийн зорилгыг дэмжих судалгаанд оролцогч нэгжүүдийн хэлэлцээрийг оруулахын зэрэгцээ судалгааны үр дүнг илтгэхэд түгээмэл хэрэглэдэг таниулах хэлбэрийг тусгаж болох юм.

Тогтмол явагддаг ажил хэрэгч уулзалт нь ийм сүлжээнүүдэд хойшид зайлшгүй шаардлагатай. Хөтөлбөрүүд болон энгийн сүлжээний судалгааны зорилгын талаар бүс нутгийн хэмжээний, их сургуулиуд, хүрээлэнгүүдэд суурилсан ийм хэлэлцээрүүд нь дараах гурван ойлголтод нийцсэн байх ёстой болов уу. Үүнд: оновчтой байх, солилцоо тогтмол явуулах, холбоо харилцаатай байх.

Оновчтой байх гэдэг нь судалгааны төвүүдийн дунд хамтарсан үндэслэлээр зохион байгуулагдсан судалгааны үйл ажиллагааг сайжруулах зорилгоор санхүүгийн болон хүн хүчний нөөцийн тусгай багцийг байрлуулахад чиглэсэн ухаалаг шийдвэр юм. Жишээлбэл, судалгааны салангид төвүүдийн хүчийг ашиглах тусгай сэдвээр судалгаа зохион байгуулах боломжтой байж болох талтай.

Солилцоо нь судалгааны төсөлд татагдан оролцож буй тал бусад хамтран ажиллаж байгаа судалгааны төвүүдэд мэдээллийг тогтмол болон тэдгээрийн хүсэлтийн дагуу санал болгож, тэдний харилцан хүлээх үүрэг амлалтыг оруулна. Харилцан судлаачдаа тогтмол солилцож байх.

Холбоо харилцаа гэдэг нь төвүүдийн эх сүлжээний хүрээний болон гаднах үр дүнтэй харьцах бодит эрмэлзлэл юм.

Дараагийн шат нь эдгээр судалгааны сүлжээнүүдийн технологийн өгөгдлүүдийг хөгжүүлэх явдал юм. Энэхүү өгөгдлүүд нь интернетээр дамжин байршилдаа орсон хэдий ч судалгааг дахин хийж, эдгээр сүлжээг илүү үр ашигтай ажиллуулах талаар талууд хүчин чармайлт гаргаж санаачлагатай ажиллах явдал бүс нутгийн судалгааны сүлжээг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой байх биз ээ.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

1. <http://www.globalization/forestreport.htm>
[http://www.globalization/AlterNet- -The FTAA's Threat-to Water.htm](http://www.globalization/AlterNet-The FTAA's Threat-to Water.htm)
2. <http://www.globalization/report.htm>
3. <http://www.globalization/essay.htm>
4. Manuel Castells, The Rise of Network Society, vol.1, The Information Age: Economy, Society and Culture (Oxford: Blackwell, 1996, p.470)
5. Asian Perspective a Journal of Regional and International Affairs (Vol.21, No.2, fall 1997 p. 22)